

## **АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 6.5 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 78.7 %-иар давсан байна. Онгон, Уулбаян, Баруун-Урт сумдаас бусад сумд төсвийн орлогын төлөвлөгөөгөө давж биелсэн байна. Орон нутгийн төсвийн зарлага 4.8 тэрбум төгрөг болжээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 27.5 тэрбум төгрөгт хүрч, 2010 оны жилийн эцсээс 7.9 тэрбум төгрөгөөр буюу 40.2 %-иар өсчээ. Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 15.5 тэрбум төгрөг болж, 2010 оны жилийн эцсээс 4.1 тэрбум төгрөгөөр буюу 36.1 хувиар өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Газар тариалан: Тариалалтын эцсийн мэдээгээр төмс 67.1 га-д, хүнсний ногоо 30.2 га-д, тэжээлийн ургамал 29.4 га-д тус тус тариалалт хийгээд байгаа нь өнгөрсөн оноос үр тариа, тэжээлийн ургамалын тариалалт буурч, төмс, хүнсний ногооны тариалалт өссөн гүйцэтгэлтэй байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 15.4 тэрбум төгрөг болж, борлуулалт 63.8 тэрбум төгрөгт хүрсэн нь урьд оны мөн үеэс нийт бүтээгдэхүүн доогуур, харин борлуулалт дээгүүр гүйцэтгэлтэй байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн буурсан нь Талын гал, Эрдэнийн олз, ХХК-нууд үйлдвэрлэлт эрхлээгүйтэй холбоотой байна. Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, цайрын баяжмал, дулаан үйлдвэрлэлт, замын хавтан, боржуур нэмэгдсэн.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний үнийн индекс 7-р сард 2010 оны эцсийнхээс 1.6 хувиар өслөө. Энэхүү өсөлтийн цаана хувцас, бөс, бараа, гутлын бүлгийн үнэ 1.3 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисийн бүлгийн үнэ 2.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 2.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 2.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 6.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 6.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 16.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 2.4 хувиар буурч бусад бүлгийн үнэ 2010 оны жилийн эцсийн үнэтэй адил түвшинд байна.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** 741 эх амаржиж, 746 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна. Халдварт өвчнөөр 350 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 57-оор олон байгаа бөгөөд мөөгөнцөр, салхицэцэг, тэмбүү, трихоминиаз, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1014 болж, эхний 7 сард 107-оор нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 81.1 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 19.9 хувь нь дээд, 2.9 хувь нь тусгай дунд, 34.1 хувь нь бүрэн дунд, 7.7 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна. Эхний 7 сард 2145 хүн шинээр бүртгүүлж, 1812 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 648 хүн ажиллаж байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** Бүртгэгдсэн гэмт хэрэг 128 байгаа нь урьд оны мөн үеэс дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 26 хүн нас барж, 36 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс өссөн байна. ААНБ, иргэдэд 25.4 сая төгрөгийн хохирол учирсны 23.5 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 129 хүн сэжиглэгдсэний 13.9 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 1533 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 99 хүнээр олон байгаа бөгөөд баривчлуулсан хүний тоо урьд оны мөн үеэс дээгүүр байна.

**IX.МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ:** Төслийн хүрээнд 3 даатгалын нэгжийн төлөөлөгч ажиллаж, 8-р сарын 12-ны байдлаар 9 сумын 159 өрхийн 33.7 мянган малыг даатгалд хамруулан, 15.3 сая төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна.

## **АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**